



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/659

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх ажлын хэсэг байгуулж тооллогын ажлыг чанартай зохион байгуулан ажиллахыг сумдын засаг дарга, ажлын хэсэгт тус тус үүрэг болгосугай.

3. Сумдад агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллого хийх, дүн мэдээг нэгтгэх, цахим санд оруулах, аргачилсан зөвлөмж өгч мэргэжлийн удирдлагаар хангаж, үнэн зөв мэдээлэл гаргахад хамтран ажиллахыг аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга Б.Өнөрбатад үүрэг болгосугай.

4. Сумд агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл эз хийж дүнгээ 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвд ирүүлэхийг сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Аймгийн хэмжээний агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн нэгдсэн дүнг мэдээллийн цахим санд оруулах, тайлан мэдээг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 12
дугаар сарын 04-ний өдрийн А/65 дугаар
захирамжийн хавсралт

АГААР БОХИРДУУЛАГЧ ЭХ ҮҮСВЭРИЙН
ТООЛЛОГО ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ



Ажлын хэсгийн ахлагч:

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн Байгаль орчны газрын дарга
Аймгийн Татварын газрын дарга
Мөрөн сумын Засаг дарга
Сумдын засаг дарга нар
Сумдын багийн дарга нар
Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч
Сумдын байгаль хамгаалагч
Сумдын цаг уурын өртөө, харуулын техникч

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга

_____оОо_____